



**МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ
ӨДРИЙН ХЭЛЭЛЦЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ**

Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар, цаашид Талууд гэх,

Монгол, Оросын харилцааг цаашид бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан,

Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн Хэлэлцээрийн (цаашид Хэлэлцээр гэх) 10 дугаар зүйлийг харгалзан,

Дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 дүгээр зүйл

Хэлэлцээрт дараах өөрчлөлтийг оруулна. Үүнд:

1) 4 дүгээр зүйлд.

1 дүгээр заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

“1. Талуудын эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын “Чингис хаан” олон улсын нисэх буудлын (ICAO-ийн нисэх буудлын код: ZMCK) агаарын хөлгийг түлшээр цэнэглэх дэд бүтцийг (цаашид Байгууламж гэх) удирдах болон ашиглах Хамтарсан компани байгуулна.”;

5 дугаар заалтад “газрын тосны бүтээгдэхүүн” гэж заасныг “агаарын хөлгийн түлш” гэж өөрчлөх;

2) 7 дугаар зүйлийн 2 дугаар догол мөрийг хасах;

3) 9 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулна:

“2. Хэрэв маргаан эхэлсэн өдрөөс хойш 2 сарын дотор шийдвэрлэгдэхгүй тохиолдолд талуудын аль нэг талын хүсэлтээр маргааныг Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотод байрлах Беларусын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Олон улсын арбитрын шүүхэд тус шүүхийн 2011 оны журмын дагуу хэлэлцүүлэхээр шилжүүлнэ”;

4) 11 дүгээр зүйлийн эхний догол мөрийг хасах;

5) 12 дугаар зүйлд:

Хоёрдугаар догол мөрөнд “20 жил” гэснийг “15 жил” гэж өөрчлөх;

Хоёрдугаар догол мөрний араас дараах агуулга бүхий догол мөр нэмэх:


“Талуудын аль нэг тал нь нөгөө Талд Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг дуусгавар болгох тухай хүсэлтийг Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх үндсэн хугацаа болон сунгагдсан дараа, дараагийн 5 жилийн хугацаа дуусгавар болохоос 1 жилийн өмнө бичгээр мэдэгдэх хүртэл Хэлэлцээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа аяндаа дараагийн 5 жилийн хугацаанд сунгагдана.”

2 дугаар зүйл

Энэхүү Протокол нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай дотоодын процедурыг дуусгавар болгосон тухай бичгээр дипломат шугамаар мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс, чингэхдээ Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

_____ хотод _____ оны ____ дүгээр сарын ____ - ний өдөр монгол, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

